

УНДАЙ ГОЛЫГ ХАМГААЛАХ, ГОЛЫН ГОЛДРИЛД ХЭСЭГЧИЛСЭН ТОХИРУУЛГА ХИЙХ

БИДНИЙ ҮҮРЭГ АМЛАЛТ:

- Ундай голыг хамгаалах, голын голдрилд хэсэгчилсэн тохируулга хийж голын дагуу байрлах малчид, зэрлэг амьтдад хүрэлцэхүйц тасралтгүй урсгалыг баталгаажуулах
- Ургамал амьтны суурьшил болон бэлчээрийн газрыг хамгаалах зорилгоор газар нутгийг нөхөн сэргээх
- Голдрил өөрчлөлтийн бүсэд орсон, ил уурхайн ойролцоо оршиж буй Бор-Овоо булгийг орлуулан гаргах.

ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ:

- Оюу Толгойн ил уурхай болон хаягдал чулуулгийн овоолгыг дамжин өнгөрч буй Ундай голын 6.8 км хэсэгт үзүүлэх нөлөөлөл
- Бор-Овоо булаг ширгэх.

БИДНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:

УНДАЙ ГОЛЫГ ХАМГААЛАХ, ГОЛЫН ГОЛДРИЛД ХЭСЭГЧИЛСЭН ТОХИРУУЛГА ХИЙХ ТӨЛӨВЛӨГӨӨ:

- Голын голдрилд хэсэгчилсэн тохируулга хийх нарийвчилсан үйл ажиллагааг орон нутгийн ард иргэд болон экосистемд хамгийн бага хэмжээнд нөлөөлөл





үзүүлэхүйцээр ус судлалын нарийвчилсан судалгаа, инженерийн шийдэлд тулгуурлан хэрэгжүүлэх

- Голын голдрилд хийх хэсэгчилсэн тохируулгыг ил уурхай болон хаягдал чулуулгийн овоолгын дээд хэсгээс урсан ирж буй байгалийн урсцыг замаас нь барьж, чиглэлийг өөрчлөн уруу урсган уурхайн доод голын сайр руу оруулах
- Голын голдрилд хийх хэсэгчилсэн тохируулгыг үерийн ус нь зэргэлдээх хөндийгөөр дамжин уурхайг тойрон Ундай голын доод урсгалд цутгахаар төлөвлөн хийх
- Голын голдрилд хийх хэсэгчилсэн тохируулгын урсцын дээд болон доод төгсгөлүүдэд хаалт хийн усыг ил уурхайгаас бүрэн тусгаарлах
- Голын доод хэсэгт буй худгуудын усны түвшин болон чанарт хяналт шинжилгээ хийн Ундай голын голдрилд хийх хэсэгчилсэн тохируулгын үр ашгийг хэмжих.

ШИНЭЭР БУЛАГ ГАРГАХ:

- Малчид болон зэрлэг амьтдын тогтвортой усан хангамжийг хангах зорилгоор уурхайн талбайгаас доош урсах Ундайн голын голдрилд хийх хэсэгчилсэн тохируулгын үйл ажиллагааны хүрээнд Бор-Овоо булгийг шинээр орлуулан гаргах
- Шинээр орлуулан гаргах булаг нь зэрлэг амьтад, малчид, мал сүргийг усаар тогтвортой хангахуйц анхны Бор-Овоо булагтай ижил шинж чанартай байхаар хийх
- Шинээр үүсгэсэн булгийн үр ашгийг баталгаажуулахын тулд иргэдтэй хэлэлцүүлэг болон оролцооны хяналт шинжилгээ хийх үйл ажиллагааг үргэлжлүүлэн, боломжит нөлөөллийг бүрэн хэмжээгээр бууруулах.

ТӨР БОЛОН АРД ИРГЭДИЙН ДЭМЖЛЭГИЙГ АВАХ:

- Нөлөөлөлд өртсөн орон нутгийн ард иргэдтэй хийх хэлэлцүүлгүүдийг хэрэгжүүлэн дуусгасан
- Голын голдрилд хийх хэсэгчилсэн тохируулгын талаархи зөвшөөрлүүдийг авах тал дээр Монгол Улсын холбогдох эрх бүхий байгууллага болон орон нутгийн ард иргэдтэй үргэлжлүүлэн хамтран ажиллах
- Санал бодлыг нь сонсох, эргэх холбоог бий болгох чиглэлээр орон нутгийн ард иргэдийг үргэлжлүүлэн татан оролцуулах.

Дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд (БОННУ) тусгагдсан Усны менежментийн төлөвлөгөөнөөс үзнэ үү.

БОННУ-г www.ot.mn цахим хуудас болон дор дурьдсан олон нийтийн газруудаас авч болно:

- Ханбогд, Манлай, Баян-Овоо болон Даланзадгад сумд дахь Оюу Толгойн салбар оффис
- **Ханбогд сум:** Ёслолын Өргөө
- **Манлай сум:** ЗДТГ-ын Мэдээллийн танхим
- **Баян-Овоо сум:** Дунд сургууль
- **Даланзадгад:** Төв номын сан болон Иргэний танхим
- **Улаанбаатар:** Оюу Толгойн Мэдээллийн Төв.